



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ**

2026 оны 03 сарын 26 өдөр

Дугаар 41

Улаанбаатар хот

Сонгон шалгаруулалтад шалгарсанд тооцож,  
тусгай зөвшөөрөл олгох тухай

Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 2.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5<sup>1</sup> дүгээр зүйлийн 5<sup>1</sup>.1.8 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 11.4, 11.7 дахь хэсэг, Зохицуулах хорооны даргын 2026 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/30 дугаар тушаалаар байгуулагдсан сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эм жи эл радио ньус ХХК-ийг “Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумдын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрөл олгох багц бүхий сонгон шалгаруулалт”-д шалгарсанд тооцсугай.
2. Эм жи эл радио ньус ХХК-д Өмнөговь аймгийн Цогтцэций, Ханбогд сумдын нутаг дэвсгэрт радио өргөн нэвтрүүлгийн станцад 88.3 МГц-ийн радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах тусгай зөвшөөрлийг 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс 2031 оны 03 дугаар сарын 26-ны өдөр хүртэл 5 жилийн хугацаатайгаар олгосугай.
3. Тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 өдрийн дотор гэрээ байгуулах үүрэгтэй болохыг дурдсугай.
4. Тусгай зөвшөөрөл олгосон этгээдтэй тусгай зөвшөөрлийн гэрээ байгуулах, энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Ж.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ

ГИШҮҮД

М.БАТТУЛГА

Ч.ЗОЛБАЯР

А.ЛУВСАН-ОЧИР

Б.МЯГМАРНАРАН

С.ТАМИР

А.ҮЙЛСТӨГӨЛДӨР